



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, НЭГТГЭСЭН ДҮНГИЙН ТАЙЛАН

2025 оны 01 дүгээр сар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn

2025 он

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Зургийн товъёг.....	Error! Bookmark not defined.
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
1.1 Аудитын нэр:	7
1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:.....	7
1.3 Үндэслэл, зорилго:	7
1.4 Хамрах хүрээ:.....	7
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ, СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН	8
2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл.....	8
2.2 Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан	9
2.3 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл	10
2.4 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал.....	13
ГУРАВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	13
3.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар	13
ДҮГНЭЛТ:.....	14
2. Аймгийн ИТХ-д 2 нэр дэвшигч, Сумдын ИТХ-д 230 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг байна.	14

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль
АН	Ардчилсан нам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИЗНН	Иргэний зориг, ногоон нам
МАН	Монгол ардын нам
НА	Нийцлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн сонгуульд нам, нэр дэвшигчдийн бүртгэл	8
Хүснэгт 2	Нам, нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн тайлан	9-10
Хүснэгт 3	Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр	10-11
Хүснэгт 4	Сонгуулийн зардлын гүйцэтгэл	11-12
Хүснэгт 5	Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл	13

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График №01	Аймгийн ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын гүйцэтгэл	12
График №02	Сумын ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын гүйцэтгэл	12

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Хувийн аудитын компаниар дүгнэлт гаргуулж ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүгнэлт гаргах, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд оршино. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Нам эвсэл, нэр дэвшигч нь сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх
- Нам эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлыг хуулийн дагуу зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн хувийн аудитын компаниар дүгнэлт гаргаж ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС 100, 400, АДБОУС 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-6:2020, МУЕА-ын тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар аргачлал”, дарга тэргүүлэх аудиторов 2024 оны “Журам, маягт, заавар аргачлал батлах тухай” А/20 дугаар тушаалаар баталсан журмыг баримтлан сонгуулийн зардлын тайлангийн талаар нам эвсэл, нэр дэвшигч, ХАК-ний холбогдох албан тушаалтнуудаас асуулга, лавлагаа авах, нам эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайлангийн орлого, зарлага, хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгжийн талаарх судалгаа, мэдээллийг нэгтгэх, баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулах дүгнэлт боловсруулж нийтэд мэдээлнэ.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, Д.Назгүл, аудитор Х.Манаргүл, Б.Үүрийнтуяа, Х.Еркебулан, С.Нурлан, Ш.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэж, тайлагнах үе шатны ажлыг 2025 оны 1 дүгээр сарын 08-ны дотор хийж гүйцэтгэв

Хүндрэл бэрхшээл

Байхгүй

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Аудитын нэр:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аудитыг гүйцэтгэсэн.

1.3 Үндэслэл, зорилго:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

1.4 Хамрах хүрээ:

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт, материалуудыг хамруулсан.

Аймгийн ИТХ-ын сонгуулийн 33 тойрогт 3 намаас 88, бие дааж 5, нийт 93 иргэн нэр дэвшсэн бөгөөд Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2 нам, 91 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан баталгаажуулж ирүүлсэн байна.

Сумдын ИТХ-ын сонгуулийн 100 тойрогт 2 намаас 623, бие дааж 2, нийт 625 иргэн нэр дэвшсэн бөгөөд Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 396 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан баталгаажуулж ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3¹-д заасны дагуу арилжааны банкнуудаас сонгуулийн зардлын данс нээлгэсэн нэр дэвшигчдийн дансны хуулгыг ирүүлсэн байна.

1.5 Арга зүй:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 10

¹ 57.3. Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага энэ хуулийн 57.2-т заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй

дугаар сарын 15-ний өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Журам, маягт, заавар, аргачлал батлах тухай” журам, АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-6:2020, “Нийцлийн аудитын заавар аргачлал”-ыг мөрдлөг болгосон.

ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ, СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3²-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт аймгийн ИТХ-д нэр дэвшүүлсэн 93 иргэнээс 87 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг ирүүлж, 6 нэр дэвшигч дансны мэдээллээ бүртгүүлээгүй байна.

Сумдын ИТХ-д нэр дэвшүүлсэн 625 иргэнээс 289 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг ирүүлж, 336 нэр дэвшигч дансны мэдээллээ бүртгүүлээгүй байна.

Орон нутгийн сонгуульд 3 нам оролцсон ба Ардчилсан нам, Монгол ардын намаас, сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг ирүүлж, Иргэний зориг Ногоон намаас мэдээлэл ирүүлээгүй байна.

Хүснэгт №01 Орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны бүртгэлийн нэгтгэл

№	Аймаг, сумдын нэр	Нийт нэр дэвшигчийн тоо	Үүнээс:	
			БӨ ТАГ-т бүртгүүлсэн	БӨ ТАГ-т бүртгүүлээгүй
1	Алтай сум	43	19	24
2	Алтанцөгц сум	42	39	3
3	Баяннуур сум	50	0	50
4	Бугат сум	38	38	0
5	Булган сум	50	50	0
6	Бүянт сум	39	26	13
7	Дэлүүн сум	49	18	31
8	Ногооннуур сум	50	6	44
9	Сагсай сум	49	3	46
10	Толбо сум	41	19	22
11	Улаанхус	58	15	43
12	Цэнгэл сум	58	0	58
13	Өлгий сум	58	56	2
	Сумын дүн	625	289	336
	Аймгийн дүн	93	87	6
	НИЙТ ДҮН	718	376	342
1	АН		1	
2	МАН		1	
3	ИЗНН			1

Эх сурвалж: Нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны бүртгэл

²50.3. Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй

Сонгуулийн зардлын дансны мэдээллийг бүртгүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3³, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12⁴, -т заасны дагуу аймгийн Татварын газарт хүргүүлээ.

2.2 Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.3⁵-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт аймгийн ИТХ-д нэр дэвшүүлсэн 93 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлэхээс 91 нэр дэвшигч ирүүлж, 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй байна.

Сумдын ИТХ-д нэр дэвшүүлсэн 625 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлэхээс 396 нэр дэвшигч ирүүлж, 229 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй байна.

Орон нутгийн сонгуульд оролцсон Ардчилсан нам, Монгол ардын нам сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлсэн ба Иргэний зориг, Ногоон нам тайлангаа ирүүлээгүй байна

Хүснэгт №2 Нам, нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн тайлангийн нэгтгэл

№	Аймаг, сумдын нэр	Нийт нэр дэвшигчийн тоо	Үүнээс:	
			Сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн	Сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй
1	Алтай сум	43	29	14
2	Алтанцөгц сум	42	26	16
3	Баяннуур сум	50	1	49
4	Бугат сум	38	38	0
5	Булган сум	50	50	0
6	Буянт сум	39	26	13
7	Дэлүүн сум	49	27	22
8	Ногооннуур сум	50	25	25
9	Сагсай сум	49	45	4
10	Толбо сум	41	23	18
11	Улаанхус	58	17	41
12	Цэнгэл сум	58	33	25
13	Өлгий сум	58	56	2
	Сумын дүн	625	396	229
	БӨ аймаг	93	91	2

³57.2.3. Сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх

⁴6.12. татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил

⁵ 56.3. Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

	НИЙТ ДҮН	718	486	
1	АН		1	
2	МАН		1	
3	ИЗНН			1

Эх сурвалж:Хуулийн этгээдээр баталгаажуулж ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

Сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй нам, нэр дэвшигчдийн жагсаалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22⁶-т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүллээ.

2.3 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн аймгийн ИТХ-ын нийт 33 тойрогт нэр дэвшсэн 91 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангаар нийт 381.8 сая төгрөгийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэн, 375.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Сумын ИТХ-ын нийт 100 тойрогт нэр дэвшсэн 395 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангаар нийт 217.0 сая төгрөгийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэн, 213.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Ардчилсан нам, Монгол ардын намаас ирүүлсэн сонгуулийн зардлын тайланд ажил гүйлгээ гараагүй байна.

Санхүүжилт

Аймгийн ИТХ-ын нийт 91 нэр дэвшигч сонгуулийн зардлын эх үүсвэрт нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс 77.7 сая төгрөг, 624 иргэний өгсөн мөнгөн хандиваар 264.0 сая төгрөгийн, 11 хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандиваар 40.2 сая төгрөг нийт 381.8 сая төгрөг, сумын ИТХ-ын нийт 395 нэр дэвшигч сонгуулийн зардлын эх үүсвэрт нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс 32.6 сая төгрөг, 859 иргэний өгсөн мөнгөн хандиваар 181.1 сая төгрөгийн, 3 хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандиваар 3.3 сая төгрөг нийт 217.0 сая төгрөг бүрдүүлсэн гэж тайлагнасан байна. *Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт 1-д үзүүлэв.*

Хүснэгт №03 Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр

№	Санхүүжилт, эх үүсвэр	Аймгийн ИТХ		Сумын ИТХ	
		Иргэн, хуулийн этгээдийн тоо	Дүн /сая төг/	Иргэн, хуулийн этгээдийн тоо	Дүн /сая төг/
1	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө		-		
2	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		77.7		32.6
3	Иргэний өгсөн	624	264.0	859	181.1

⁶ 6.22. нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;

	Үүнээс: Мөнгөн хандив		264.0		181.1
	Мөнгөн бус хандив		-	5	-
4	Хуулийн этгээдийн өгсөн	11	40.2	3	3.3
	Үүнээс: Мөнгөн хандив		40.2		3.3
	Мөнгөн бус хандив		-		-
	Нийт дүн		381.8		217.0

Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

Зардал

Аймгийн ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд нийт 91 нэр дэвшигч 375.0 сая төгрөгийг зарцуулснаас, сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал 15.2 хувийг, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал 1.0 хувийг, сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал 2.1 хувийг, сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал 77.7 хувийг, сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал 0.7 хувийг, сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал 0.8 хувийг, бусад зардал 2.5 хувийг тус тус эзэлж байна.

Сумын ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд нийт 395 нэр дэвшигч 213.0 сая төгрөгийг зарцуулснаас, сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал 9.4 хувийг, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал 0.6 хувийг, сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал 0.8 хувийг, сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал 81.1 хувийг, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал 0.6 хувийг, бусад зардал 7.4 хувийг тус тус эзэлж байна. *Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт 2-т үзүүлэв.*


Хүснэгт №04 Сонгуулийн зардлын гүйцэтгэл

№	Зардлын ангилал	Аймгийн ИТХ-ын дүн /сая төг/	Эзлэх хувь	Сумын ИТХ-ын дүн /сая төг/	Эзлэх хувь
1	Сонгуулийн зардал	365.6	97.5	197.3	92.6
1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал	56.9	15.2	20.0	9.4
1.2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	3.8	1.0	1.4	0.6
1.3	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	-		-	
1.4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	7.7	2.1	1.8	0.8
1.5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	291.5	77.7	172.8	81.1
1.6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	2.7	0.7	-	
1.7	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал	-		1.3	0.6

1.8	Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал	3.0	0.8	-	
2	Бусад зардал	9.4	2.5	15.7	7.4
	Нийт дүн	375.0	100.0	213.0	100.0


Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

График №01. Аймгийн ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын гүйцэтгэл



Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

График №02. Сумын ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын гүйцэтгэл



Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

Сонгуулийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой зөрчил, дутагдал илрээгүй.

2.4 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд “Өлгий Аудит” ХХК, “Уужим алтай Аудит” ХХК, “Анализ старт Аудит” ХХК зэрэг 3 аудитын хуулийн этгээд аудит хийж, Баян-Өлгий аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/20 дугаар тушаалаар баталсан “Журам, маягт, заавар аргачлал батлах тухай” журмын дагуу баталгаажуулан ирүүлсэн байна.

ГУРАВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

3.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1⁷-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-д оролцсон нэр дэвшигчдэд 112 иргэн 163.0 сая төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандив, 7 хуулийн этгээд 38.0 сая төгрөгийн хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандив, сумын ИТХ-д оролцсон нэр дэвшигчдэд 37 иргэн 47.4 сая төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандив, 1 хуулийн этгээд 3.0 сая төгрөгийн хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна. *Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт 3-т үзүүлэв.*

Хүснэгт №05 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл

№	Үзүүлэлт	Аймгийн ИТХ		Сумын ИТХ	
		Иргэн, хуулийн этгээдийн тоо	Дүн /сая төг/	Иргэн, хуулийн этгээдийн тоо	Дүн /сая төг/
1	Иргэн /Нэг сая төгрөгөөс дээш/	112	163.0	37	47.4
1.1	Мөнгөн хандивын дүн		163.0		47.4
1.2	Мөнгөн бус хандивын дүн				
2	Хуулийн этгээд / 2 сая төгрөгөөс дээш/	7	38.0	1	3.0
2.1	Мөнгөн хандивын дүн		38.0		3.0
2.2	Мөнгөн бус хандивын дүн				
	Нийт		201.0		50.4

Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

⁷ Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймаг дахь төрийн аудитын газарт Аймгийн ИТХ-д нэр дэвшсэн 6 хүн, сумын ИТХ-д нэр дэвшсэн 336 хүн, Иргэний зориг, ногоон нам сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй байна.
2. Аймгийн ИТХ-д нэр дэвшсэн 2 хүн, Сумдын ИТХ-д нэр дэвшсэн 229 хүн, Иргэний зориг, ногоон нам сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж ирүүлээгүй байна.

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/03

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх" сэдвээр хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аймгийн Татварын газарт сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг бүртгүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалтыг, Санхүү, төрийн сангийн хэлтэст сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалтыг тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитын дүнг нийтэд мэдээллэхийг ахлах аудитор (У.Ербол)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



Ж.АЙГҮЛ